

ХИНДИ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТӨВ

Хинди хэл бол манай өнө эртний соёлын харилцаат Энэтхэг орны үндэсний хэл. Энэтхэгчүүд олон үндэстэн ястны орон боловч төрийн албан ёсны хэл нь Хинди хэл болно. Хинди хэлний тухай ойлголт магадгүй Монголчуудын дотор тэдний өнөөгийн Англи ч юмуу солонгос ч юмуу хэл сонирхох хэмжээнд хүрээгүй байх. Гэхдээ монгол, хинди хэлнүүдийн хоорондын харилцааг түүхийн талаас нь авч үзвэл олон мянган жилийн улбаатайг эрдэмтэд нотолсон байдаг.

Монголчуудад хадгалагдаж байгаа эртний болон орчин цагийн үнэт бүтээлүүд хинди, санскрит хэлнээс хөрвүүлсэн нь олонтоо байгаа нь тохиолдлын хэрэг биш. Ийм учраас хинди хэл бол монголчуудын хувьд дээр үеэс сонирхогдож, судлагдаж ирсэн.

Өнөө цагт хинди хэлийг Монголчуудад зааж сургах талаар 1992 оноос хойш тасралтгүй ажиллаж байгаа хинди хэлний албан бус сургалтын төв нь Монгол дахь Энэтхэгийн соёлын төвийн дэргэд хичээллэдэг юм. Хинди хэлний сургалт нь анхан шатнаас эхлэн дунд түвшний хэмжээнд гол төлөв ярианы ур чадварт түшиглэсэн сургалтын хөтөлбөрөөр явагддаг бөгөөд жил бүр 20 гаруй монгол охид, хөвгүүд хоёр жилийн хугацаатай суралцахаар элсдэг. Тэдний дотроос амжилттай суралцсан хоёр хүүхдийг жил бүр Энэтхэг улсын зардлаар Агра хот дахь Хинди хэлний сургалтын төвд мэргэшүүлэх сургалтад хамруулдаг. Энэ хугацаанд 180 орчим охид, хөвгүүд хинди хэлний сургалтын төвийг амжилттай төгссөн байна.

Хинди хэлний сургалтын төвд суралцагсад нь зөвхөн англи хэл сурах төдийгүй Энэтхэг улсын олон үндэстэн ястны дуу, бүжиг, хөгжмийн гайхамшигт урлагаас суралцдаг юм.

Хинди хэлний сургалтад шаардагдах ном сурах бичиг, гарын авлага, техник хэрэгслийг Энэтхэг улсаас Монгол улсад суугаа элчин сайдын яам хангаж, сургалтын үйл ажиллагаанд байнгын дэмжлэг үзүүлдэг.

Ч.Сийлэгмаа

Хинди хэлний сургалтын төвийн багш

МОНГОЛ ДАХЬ ЭНЭТХЭГ УЛСЫН СОЁЛЫН ТӨВ

Монгол дахь Энэтхэг улсын Соёлын төв нь 1992 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр байгуулагдсан бөгөөд манай улсад ажиллаж байгаа гадаад орнуудын соёл төв дотроос Оросын соёл, шинжлэх ухаан, мэдээллийн төвийн дараа байгуулагдсан соёлын ууган төвүүдийн нэг болно. Соёлын төвийг БНЭУ-ын Соёлын харилцааны зөвлөл, Монголын урлаг, соёлын үндэсний хороо, Соёлын төв өргөөний /хуучин нэрээр/ дэмжлэгтэйгээр байгуулсан юм.

Соёлын төвийн үндсэн үүрэг нь Энэтхэг улсын соёл, шинжлэх ухаан, боловсролын ололт амжилтыг монголын өргөн олон нийтэд сурталчилж, түгээн дэлгэрүүлэх зорилготой.

Энэтхэг улсын соёлын төв Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл-Урлалын сургуулийг түшиглэн ажиллаж байна.